

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
ДАРГА Э.БАТТУЛГА

2020 оны 04 сарын 06 өдөр

УОА0039 9077049

**"УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР  
БОЛОВСРУУЛАХТАЙ ХОЛБОГДОХ СУДАЛГАА ХИЙХ"  
АЖЛЫН ДААЛГАВАР**

Монгол Улс нь хүлэмжийн хийн ялгаруулалт харьцангуй бага хэдий ч газар зүйн байршил, эмзэг экосистем, байгаль цаг агаараас хараат эдийн засгийн тогтолцоо зэргээс шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий бөгөөд түүний үр дагавар нь цөлжилт газрын доройтол, усны болон ойн сангийн хомсдол, байгалийн гамшигт үзэгдлийн тоо давтамж зэргээр хүчтэй илэрч байна.

1992 оны 6 дугаар сарын 3-14-ны өдрүүдэд Рио Дэ Жанейро хотноо зохион байгуулагдсан НҮБ-ын "Байгаль орчин ба эдийн засгийн хөгжил" бага хурлаар хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хийн мандал дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн олон улсын эрх зүйн томоохон баримт бичиг болох "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц"-ийг баталсан ба Монгол Улс тус конвенцид 1993 оны 6 дугаар сарын 1-ний өдөр нэгдэн орсон.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Талуудын 21 дүгээр Бага хурлаар дэлхийн агаарын дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн үетэй харьцуулахад 2°C-д барих, цаашлаад 1,5°C-д хүргэхэд чиглэгдсэн цогц баримт бичиг болох "Парисын хэлэлцээр"-ийг баталсан. Монгол Улс 2016 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Парисийн хэлэлцээрийг соёрхон баталсан. Уг хэлэлцээр нь 2020 оноос нэгдсэн байдлаар хэрэгжиж эхэлж байгаа бөгөөд гишүүн орон бүр өөрсдийн оруулах хувь нэмэр (Nationally determined contribution)-г тодорхойлж, таван жил тутам зорилтоо ахиулж, хэрэгжилтийг тайлагнаж байх үүрэгтэй.

Энэхүү үүргийн дагуу Монгол Улс 2019 онд үндэсний зорилтоо шинэчилж, хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулахаар өмнө нь дэвшүүлсэн зорилтоо ахиулан тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицоход чиглэсэн арга хэмжээг тодорхойлсон. Нэгдсэн дүнгээр Монгол Улс үндэсний хүлэмжийн хийн ялгарлаа нийт ялгаруулах суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7% буюу 16.89 сая тонн CO<sub>2</sub>-той дүйцэхүйц хүлэмжийн хийг бууруулах боломжтой гэж үзсэн. Харин газар ашиглалт, ойн салбарын салбарын хүлэмжийн хийн шингээлт (11.2%)-ийг тооцож үзвэл Монгол Улс нийт хүлэмжийн хийн ялгаралтаа 2030 он гэхэд 33.9 % бууруулах боломжтой юм.



АЖЛЫН ДААЛГАВАР

1	Үндэслэл:	<p>Монгол Улс үндэсний зорилтоо ахиулан шинэчилсэнтэй уялдуулж нийслэл хотын оролцоог дахин тодотгох, газар ашиглалт, ойн салбарын хүлэмжийн хийн шингээлтийн тооцоог оруулах хэрэгцээ үүсээд байна.</p> <p>Судалгааны дүнгээс харахад сүүлийн 75 жилд Улаанбаатар хотын жилийн дундаж температур 2.6 °C (Монгол орны өөрчлөлтөөс 0.4 °C-ээр их)-ээр нэмэгдэж, жилийн нийлбэр хур тунадас 5%-иар буурсан байна. Мөн сүүлийн жилүүдэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын буруутай үйл ажиллагаанаас Улаанбаатар хотын хөрсний 13.6 хувь нь ямар нэг хэмжээгээр эвдэрсэн бол нийт эвдэгдсэн талбайн 70.1 хувь нь хүчтэй доройтон цөлжсөн байдалтай байна. Хот орчмын жилийн дундаж температур ойрын ирээдүйд (2016-2035 он) үед хүлэмжийн хийн ялгарлын бүх хувилбарт бараг ижил 1.0-1.5°C, харин ХХЯ-аас хамааран дунд ирээдүйд (2046-2065 он) улирлын температур 3.1°C, алсын ирээдүйд (2081-2100 он) 5.6°C хүртэл нэмэгдэж дулаарахаар байна. Хур тунадасны хувьд өвлийнх нэмэгдэхээр, харин бусад улирлынх ялимгүй өсөлттэй гарч байна. Иймд, Улаанбаатар хотын ой, ус, хөрс болон биологийн олон янз байдлыг хамгаалах замаар уур амьсгалын өөрчлөлтийн бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаварт байгаль орчин, экосистемийн өртөх байдлыг бууруулах, зэрэг нөлөөлөл, таатай нөхцөлийг аль болох бүрэн дүүрэн ашиглахад чиглэсэн экосистемд түшиглэсэн дасан зохицох, даван туулах шийдлүүдийг тодорхойлох шаардлагатай байна.</p>
2	Хамрах хүрээ:	Улаанбаатар хот
3	Ажил гүйцэтгэх хугацаа:	Ажлын 40 хоног
4	Хийж гүйцэтгэх ажил:	<ul style="list-style-type: none"> <li>- Бодлогын баримт бичгийн тойм</li> <li>- Үндэсний зорилтот хувь нэмэр дэх нийслэл хотын оролцоог дахин тодотгох, газар ашиглалт, ойн салбарын хүлэмжийн хийн шингээлтийн тооцоог хийх</li> <li>- Нийслэл хотын нутаг дэвсгэрт экосистемд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох шийдэл, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх төслийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх</li> <li>- Сонгосон төслүүдийн давуу болон сул талуудын нарийвчилсан дүн шинжилгээ</li> </ul>

5	Хүлээн авах, ажил, үйлчилгээ:	- Нийслэлийн Байгаль орчны газрын даргын тушаалаар батлагдсан ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгнө. - Санхүүгийн болон ажлын тайлан.
6	Санхүүжилтийн эх үүсвэр:	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал
7	Захиалагч байгууллага:	Нийслэлийн Байгаль орчны газар
8	Хүрэх үр дүн:	Монгол Улсын нийт хүн амын 45% нь оршин суудаг, ДНБ-ийн 64%-ийг үйлдвэрлэдэг, хүлэмжийн хийн ялгарлын гол эх үүсвэр болсон нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцууд, эрчим хүчний томоохон хэрэглэгчдийн ихэнх нь төвлөрсөн нийслэл хот биологийн олон янз байдлыг хамгаалсан, экосистемд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, дасан зохицсон арга хэмжээг тодорхойлсон биеэ даасан бодлогын баримт бичиг, тодотгосон суурь судалгаатай болно.
9	Төсөв:	<b>20.0 сая.төг</b>

Хянасан:

ХБОБНХ-ийн дарга



М.Чинсанаа

Боловсруулсан:

ХБОБНХ-ийн мэргэжилтэн



С.Энхээ